



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК-ний 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/133/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал Утас: 7000-7734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 325093 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ари файнэнс аудит ХХК-ийн захирал: Д.Ариунаа Утас: 99088151 Цахим хаяг: arifin.audit@gmail.com
-----------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.13 № 711
танай _____-ны № _____-т

УЛААНБААТАР ХОТЫН ХӨГЖЛИЙН
КОРПОРАЦИ ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Л.ТЭМҮҮЖИН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийтийн тээврийн үйлчилгээнд явж буй туршилтын цахилгаан 8 автобусыг тээврийн хэрэгслийн гэрчилгээг нь ашиглаж буй Зорчигч тээвэр 2 ОНӨААТҮГ-ын нэр дээр шилжүүлсэн бөгөөд мөн гаалийн талбайд хадгалагдаж байсан 2 автобусыг Зорчигч тээвэр 2 ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгч, үйлчилгээнд гаргасан байна.

Аудитын гол асуудал

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/52 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын нэгдсэн сошиал платформыг нийслэлийн хэрэглээнд нэвтрүүлэх Оюуны өмчийн газрын 14018 дугаартай “Хотула” нэртэй зохиогчийн эрхтэй бүтээлийг эзэмшигч “Дижитал Инфосек” ХХК-ийн 34.0 хувийн хувьцааг Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК шилжүүлж авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Нийтийн тээврийн хэрэгслээр зорчих картыг худалдан борлуулах, арилжааны банкинд данс нээж карт борлуулалтын болон цэнэглэлтийн орлогыг хүлээн авах, нийтийн тээврийн үйлчилгээний орлогыг төвлөрүүлэх төслийн ажлыг Нийслэлийн

Засаг даргын 2025 оны MN/19 захирамжаар Улаанбаатар смарт карт ХХК-д шилжүүлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	7,285,714,839.70	7,902,414,563.71
1.1.02	Дансны авлага	46,319,307.14	410,280,000.00
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	100,940,266.93	112,241,421.58
1.1.04	Бусад авлага	7,401,510,864.78	8,959,460,308.11
1.1.06	Бараа материал	7,823,922.85	10,794,422.52
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	0.00	71,681,818.18
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	14,842,309,201.40	17,466,872,534.10
1.2.01	Үндсэн хөрөнгө	25,234,976,543.72	18,056,855,520.40
1.2.02	Биет бус хөрөнгө	1,503,684,605.91	3,558,959,640.00
1.2.04	Урт хугацаат хөрөнгө оруулалт	66,840,000.00	66,846,800.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	26,805,501,149.63	21,682,661,960.40
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	41,647,810,351.03	39,149,534,494.50
2.1.1.01	Дансны өглөг	1,731,624.14	875,402,022.91
2.1.1.02	Цалингийн өглөг	265,992.06	0.00
2.1.1.03	Татварын өр	28,349,491.97	0.00
2.1.1.04	НДШ - ийн өглөг	131,610.00	0.00
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	2,184,400.00	3,588,181.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	127,194,337.50	111,811,137.50
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	159,857,455.67	990,801,341.41
2.2	Өр төлбөрийн нийт дүн	159,857,455.67	990,801,341.41
2.3.02	- хувийн	11,670,000,000.00	11,670,000,000.00
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4,890,302,866.77	4,890,302,866.77
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	23,637,185,617.28	19,190,346,981.29
2.3.09	Хуримтлагдсан ашиг	1,290,464,411.31	2,408,083,305.03
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	1,117,618,893.72
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	1,290,464,411.31	1,290,464,411.31
2.3.11	Эздийн өмчийн дүн	41,487,952,895.36	38,158,733,153.09
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	41,647,810,351.03	39,149,534,494.50

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	2,081,321,125.29	3,880,315,904.50
02	Борлуулалтын өртөг	1,334,308,840.65	2,445,519,190.68
03	Нийт ашиг(алдагдал)	747,012,284.64	1,434,796,713.82
04	Түрээсийн орлого	494,410,490.72	665,312,106.94
05	Хүүний орлого	969,208,112.69	622,181,074.29
06	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
07	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
08	Бусад орлого	0.00	1,036,363.64
08.1	Орлогын дүн	1,463,618,603.41	1,288,529,544.87
09	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	957,927,855.71	1,282,702,280.04

Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК-ний 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	0.00	19,713,844.67
12.1	Зардлын дүн	957,927,855.71	1,302,416,124.71
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	9,293.85	39,866.43
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-16,054,632.40	-12,289,718.86
17	Бусад ашиг (алдагдал)	-97,493,178.90	-201,585,200.00
17.1	Олз, гарзын дүн	-113,538,517.45	-213,835,052.43
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	1,139,164,514.89	1,207,075,081.55
19	Орлогын татварын зардал	125,270,303.25	89,456,187.83
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,013,894,211.64	1,117,618,893.72

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	11,670,000,000.00	4,890,302,866.77	23,637,185,617.28	371,570,199.67	40,569,058,683.72
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	1,013,894,211.64	1,013,894,211.64
09	2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	11,670,000,000.00	4,890,302,866.77	23,637,185,617.28	1,290,464,411.31	41,487,952,895.36
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	1,117,618,893.72	1,117,618,893.72
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	-4,446,838,635.99	0.00	-4,446,838,635.99
17	2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	11,670,000,000.00	4,890,302,866.77	19,190,346,981.29	2,408,083,305.03	38,158,733,153.09

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,050,193,751.75	11,311,809,022.35
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,625,745,995.72	2,936,126,820.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	180,479,541.80	529,220,123.80
1.1.6	Бусад мөнгөн орлого	243,968,214.23	7,846,462,078.55
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	8,478,628,545.54	9,774,034,391.06
1.2.1	Ажиллагчдад төлсөн	901,017,454.91	1,170,216,561.49
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	243,907,543.94	300,644,553.48
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	11,425,935.00	19,676,579.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	58,804,442.00	129,136,025.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	31,270,781.00	32,479,657.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	282,522,800.61	629,922,307.13
1.2.9	Бусад мөнгөн зарлага	6,949,679,588.08	7,491,958,707.96

1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-5,428,434,793.79	1,537,774,631.29
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	969,208,112.69	970,628,939.63
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	348,447,865.34
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	969,208,112.69	622,181,074.29
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	66,322,040.91	1,891,743,713.34
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,110,800.00	20,708,500.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	12,860,850.00	6,517,260.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	6,800.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	49,350,390.91	1,864,511,153.34
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	902,886,071.78	-921,114,773.71
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	34,249.62	51,643.47
3.1.4	Бусад	34,249.62	51,643.47
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,955.77	11,777.04
3.2.5	Бусад	3,955.77	11,777.04
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	30,293.85	39,866.43
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-4,525,518,428.16	616,699,724.01
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11,811,233,267.86	7,285,714,839.70
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,285,714,839.70	7,902,414,563.71

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 оны гүйцэтгэл /2025 оны гүйцэтгэл	Хувь	2025 оны төлөвлөгөө/2025 оны гүйцэтгэл	Хувь
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	м.төг							
	а/ Гол нэр төрлөөр	м.төг	-	-	3.00				
	б/ Үнийн дүнгээр	м.төг	-	-	320,316.72				
	Нийт орлого	м.төг	3,628,601.71	4,638,360.70	5,292,031.13	0.69	69	653,670.43	114.1
2	а/ Үйл ажиллагаа, менежментийн орлого	м.төг	2,134,253.45	2,612,494.24	2,669,206.20	0.80	80	56,711.96	102.2
	б/ Түрээсийн орлого /МХО, ННС/	м.төг	252,212.37	692,474.10	693,485.27	0.36	36	1,011.18	100.1
	в/ Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	м.төг	164,072.31	813,636.36	481,109.20	0.34	34	(332,527.16)	59.1
	г/ Банкны хүүгийн орлого	м.төг	969,208.11	519,756.00	622,181.07	1.56	156	102,425.07	119.7
	д/ Бусад орлого	м.төг	108,855.47	-	826,049.38	0.13	13	826,049.38	
	Нийт зардал	м.төг	1,808,003.70	4,982,980.73	2,868,870.01	0.63	63	(2,114,110.72)	57.6
3	а/ Ерөнхий ба удирдлагын зардал	м.төг	1,808,003.70	4,982,980.73	2,668,870.01	0.68	68	(2,314,110.72)	53.6
	б/ Үйл ажиллагааны бус зардал	м.төг	-	200,000.00	200,000.00	-	-	-	100.0
4	Татварын өмнөх ашиг	м.төг	1,820,598.01	(344,620.03)	2,423,161.12	0.75	75	2,767,781.15	(703.1)
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	1,820,598.01	(344,620.03)	2,423,161.12	0.75	75	2,767,781.15	(703.1)
	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	666,808.56	857,867.17	836,038.11	0.80	80	(21,829.06)	97.5
6	а/ Орлогын татварт	м.төг	88,318.01	-	60,708.93	1.45	145	60,708.93	
	б/ НӨАТ	м.төг	255,053.81	411,860.47	344,352.90	0.74	74	(67,507.57)	83.6
	в/ НДШ	м.төг	129,245.95	210,615.80	210,615.80	0.61	61	-	100.0
	г/ Хүүний орлогын албан татвар	м.төг	96,920.81	51,975.60	62,218.11	1.56	156	10,242.51	119.7
	д/ Хувь хүний орлогын албан татвар	м.төг	94,717.59	-	-	-	-	-	-
	е/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	-	171,415.30	148,943.56	-	-	(22,471.74)	86.9
	ё/ Бусад татвар /газрын төлбөр/	м.төг	2,552.39	12,000.00	9,198.81	0.28	28	(2,801.19)	76.7
7	Ажиллагаагийн тоо	хүн	26.00	41.00	26.00	1.00	100	(15.00)	63.4
8	Нийт цалингийн сан	м.төг	1,002,181.07	1,799,894.00	1,241,718.74	0.81	81	(558,175.26)	69.0
9	Нэг ажилтны дундаж цалин	м.төг	3,212.12	3,658.32	3,979.87	0.81	81	321.55	108.8
10	Хөрөнгө оруулалт	м.төг	24.38	279,077.40	27,225.76	0.00	0	(251,851.64)	9.8
11	а/ Үндсэн хөрөнгө худалдан авалтын зардал	м.төг	24,165.65	279,077.40	27,225.76	0.89	89	(251,851.64)	9.8
	Төслийн хөрөнгө оруулалт	м.төг	6,481,172.53	6,165,438.30	1,832,828.47	3.54	354	(4,332,609.83)	29.7
12	Эрдэнэс баянбогд ХХК	м.төг	6,436,822.14	2,916,027.30	1,537,771.90	4.19	419	(1,378,255.40)	52.7
	Улаанбаатар Такси Каб ХХК	м.төг	-	670,000.00	-	-	-	(670,000.00)	-
	Улаанбаатар Энержи ХХК	м.төг	44,350.39	2,579,411.00	295,056.57	0.15	15	(2,284,354.43)	11.4
	Нийт авлага	м.төг	7,548,770.44	9,475,566.89	411,066.11	18.36	1,836	(9,064,500.78)	4.3
13	а/ Холбоотой байгууллагаас авах авлага	м.төг	7,381,517.02	9,308,313.47	349,133.16	21.14	2,114	(8,959,180.31)	3.8
	б/ Бусад авлага	м.төг	19,993.84	19,993.84	19,713.84	1.01	101	(280.00)	98.6
	в/ Татварын авлага	м.төг	100,940.27	100,940.27	6,179.80	16.33	1,633	(94,760.47)	6.1
	г/ Байгууллага хоорондын авлага	м.төг	46,319.31	46,319.31	36,039.31	1.29	129	(10,280.00)	77.8
	Нийт өглөг	м.төг	157,673.06	157,673.06	45,551.75	3.46	346	(112,121.31)	28.9
	а/ Богино хугацаат өр төлбөр үүнээс:	м.төг	157,673.06	157,673.06	45,551.75	3.46	346	(112,121.31)	28.9
14	1. Дансны өглөг	м.төг	1,731.62	1,731.62	1,421.45	1.22	122	(310.17)	82.1
	1. Татварын өр	м.төг	28,349.49	28,349.49	28,349.49	1.00	100	-	100.0
	2. Цалингийн өглөг	м.төг	265.99	265.99	265.99	1.00	100	-	100.0
	3. НДШ өглөг	м.төг	131.61	131.61	131.61	1.00	100	-	100.0
	4. Бусад өглөг	м.төг	127,194.34	127,194.34	15,383.20	8.27	827	(111,811.14)	12.1

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 400,793.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 400,793.9 мянган төгрөгийн алдааг залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

- Улаанбаатар хотын хөгжлийн корпорацн ХК нь Таван толгой түлш ХХК, Дижитал инфосек ХХК-тай байгуулсан Хатуу болон хийн түлшний хяналтын нэгдсэн системийг хөгжүүлэх гэрээт ажлын төлбөрийг аккрузал сууриар бүртгэж 400,000.0 мянган төгрөгийн тооцоо үүсгээгүй бүртгэснийг;
- Авлага өглөгийн дэлгэрэнгүй тайлангаар Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст 793.9 мянган төгрөгийн өглөгтэй, Сүхбаатар дүүргийн Татварын хэлтэсээс 793.9

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

мянган төгрөгийн авлагатай байгаа боловч санхүүгийн тайлан, ерөнхий журнал, ерөнхий дэвтэр, гүйлгээ балансд үлдэгдэлгүй зөрүүтэй бүртгэснийг;

Эдгээр нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 1.27-д “санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой”, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 “иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “үнэн зөв байх”, “иж бүрэн байх”, батламж мэдэгдлийг хангахгүй байгааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасны дагуу залруулга хийлгэж санхүүгийн тайланг баталгаажуулав.

Аудитаар нийт 1,729.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 600.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,129.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 3 зөвлөмж өгсөн.

Нийт залруулагдаагүй 1,729.5 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

3.1 Төлбөрийн акт

UBDC логотой 600.0 мянган төгрөгийн шоколад авч төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-д “Төрийн өөрийн өмчийг зориулалт бусаар захиран зарцуулах, нийгмийн шинжтэй төсөл, арга хэмжээнд зарцуулах, хандив, тусламж, түүнтэй адилтгах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглох бөгөөд энэхүү хориглолтыг зөрчсөн эрх бүхий этгээдийг албан тушаалаас чөлөөлж, учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ”; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “үр ашигтай байх”, 4.2.1-т “зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “үнэн зөв байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан 600.0 мянган төгрөгийг төлүүлж, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж, 664.6 мянган төгрөгийн урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн багц, 464.9 мянган төгрөгийн анхан шатны түргэн тусламжийн багц авч үргүй зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно; 15.1.6. нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “үнэн зөв байх”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шаардлагагүй бараа материал бэлтгэсэн зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Нийслэлийн Засаг даргын захирамжаар Улаанбаатар смарт карт ХХК-д эрх нь шилжсэн Нийтийн тээврийн карт цэнэглэлтийн орлого хүлээн авах Голомт банк дахь 2025159021 дүгээр, карт борлуулалтын орлого хүлээн авах 8125102886 дугаар дансыг Улаанбаатар смарт карт ХХК-д шилжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "*жинхэнэ хэрэгжилтийн*", 5.1.4-т "*үнэн зөв байх*", 13 дугаар зүйлийн 13.1-т "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "үнэн зөв байх", "иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нийслэлийн Засаг даргын захирамжийг хэрэгжүүлж Улаанбаатар смарт карт ХХК-д эрх нь шилжсэн нийтийн тээврийн карт цэнэглэлтийн орлого хүлээн авах мөнгөн хөрөнгийн дансыг шилжүүлэх

2. Үндсэн хөрөнгө дахин үнэлэхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт-2: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 138 нэр төрлийн (анхны өртөг 144,140.2 мянган төгрөг) хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т "*Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох*", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-т "*Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.*" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "үнэн зөв байх", "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг холбогдох байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлж ажиллах;

3. Татварын үлдэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт-3: Тайлант хугацааны эцэс дэх татварын үлдэгдлийг татварын тодорхойлолтоорх дүнтэй тулган шалгахад ХХОАТ 16,668.9 мянган төгрөгөөр, НӨАТ 50,469.6 мянган төгрөгөөр, АТБӨЯХ-ын татвар 1,156.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.7-д "Аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах" заалтыг зөрчиж, санхүүгийн тайлагналын "үнэн зөв байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, өглөг авлагыг бүрэн баталгаажуулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**4.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК нь Таван толгой түлш ХХК, Дижитал инфосек ХХК-тай байгуулсан Хатуу болон хийн түлшний хяналтын нэгдсэн системийг хөгжүүлэх гэрээт ажлын төлбөрийг аккрузал сууриар бүртгэж тооцоо үүсгээгүй 400.0 сая төгрөгийг НББ-д тусгасан.	1	400,000.0	1	400,000.0			1	400,000.0				
2	Авлага өглөгийн дэлгэрэнгүй тайлангаар Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст 793.9 мянган төгрөгийн өглөгтэй, Сүхбаатар дүүргийн Татварын хэлтэсээс 793.9 мянган төгрөгийн авлагатай байгаа боловч санхүүгийн тайлан, ЕЖ, ЕД, ГБалансд үлдэгдэлгүй байна.	1	793.9			1	793.9	1	793.9				
	Дүн	2	400,793.9	1	400,000.0	1	793.9	2	400,793.9				

4.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.Д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж, 664.6 мянган төгрөгийн урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн багц, 464.9 мянган төгрөгийн анхан шатны түргэн тусламжийн багц авч үргүй зардал гаргасан байна.	1	1,129.5			1	1,129.5						
2	UBDC логотой шоколад авч хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	1	600.0	1	600.0								
3	Нийтийн тээврийн карт цэнэглэлтийн орлого хүлээн авах дансыг Улаанбаатар смарт карт ХХК-д шилжүүлээгүй	1						1					
4	Үндсэн хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй	1						1					
5	Татварын үлдэгдлийг татварын тодорхойлолтоорх дүнтэй зөрүүтэй	1						1					
	Дүн	5	1,729.5	1	600.0	1	1,129.5	3					

4.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
1	Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК-ийн охин компани Улаанбаатар энерги ХХК-ийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 878,833.3 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй даатгалын үйлчилгээний тендерийг толгой компани зохион байгуулсан нь худалдан авах ажиллагааны захиалагчийн эрх, үүргийн нэгдмэл байдлыг алдагдуулсан, захиалгийн эрх үүргийн зохицуулалт тодорхойгүй, хууль, журмын нийцлийг хангаагүй, төлөвлөлтийн шаардлагыг зөрчсөн байна.	1	878,833.3			1	878,833.3		
	Дүн	1	878,833.3			1	878,833.3	-	-
	Нийт дүн	1	878,833.3			1	878,833.3	1	